# БАЙГУУЛЛАГЫН 2022 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/"Улаанбаатар лифт" ОНӨТҮГ/

2022 оны 12 дугаар сарын 30 Улаанбаатар хот

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв */мян. Төг/* | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Гүйцэт-гэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| **Стратеги төлөвлөгөөний зорилго 1.**<br>Лифтийн ашиглалт засвар үйлчилгээний чанарыг дээшлүүлэх, шинэ техник технологи нэвтрүүлэх, бодлого боловсруулах, түүнийг хэрэгжүүлэх зөвлөмж, аргачлал, удирдамж боловсруулна.<br><br>"Лифтийн ашиглалт засвар үйлчилгээний чанарыг дээшлүүлэх, шинэ техник технологи нэвтрүүлэх, түүнийг хэрэгжүүлэх зөвлөмж, аргачлал, удирдамж боловсруулах" гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн арга хэмжээ: | | | | | | | |
| **Зорилт 1.1**<br>Лифтийн ашиглалт засвар үйлчилгээний чанарыг дээшлүүлэх, шинэ техник технологи нэвтрүүлэх, бодлого боловсруулах, түүнийг хэрэгжүүлэх зөвлөмж, аргачлал, удирдамж боловсруулна. | | | | | | | |
| 1 | Арга хэмжээ-1.1.1<br>Лифтийн ашиглалт, засвар үйлчилгээг гэрээгээр хариуцдаг ААН байгууллага, СӨХ, иргэдийн лифтний засвар үйлчилгээг технологийн дагуу чанартай гүйцэтгэх, графикийг сар бүр гаргаж, ашиглалтын найдвартай ажиллагаа болон аюулгүй байдлыг хангаж ажиллах. | - | Техник үйлчилгээ хийсэн лифтний тоо | Техник үйлчилгээ хийсэн лифтний тоо, 1867 | 1800 лифтэнд техник үйлчилгээ хийж гүйцэтгэнэ. | Гэрээгээр хамтран ажилладаг ААНБ, СӨХ-дын цахилгаан шатанд засвар, үйлчилгээ хийх хуваарийг сар бүр гарган, газрын даргаар батлуулан ажиллаж байна.<br>53 ААНБ, СӨХ-дын 156 лифтэнд сар бүр техник үйлчилгээ хийх гэрээтэй ажиллаж байна. Жилийн эцсийн байдлаар давхардсан тоогоор 1879 лифтэнд техник үйлчилгээ хийж, өдөр тутмын ажилд хяналт тавин ажилласан. Гэрээгээр хамтран ажилладаг ААНБ, СӨХ-доос жилийн эцсийн байдлаар нийт 235 дуудлага ирсэн бөгөөд цаг хугацаанд нь шийдвэрлэж ажилласан. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Техник үйлчилгээ хийж, засвар үйлчилгээг технологийн дагуу чанартай гүйцэтгэх, графикийг сар бүр гаргаж, ашиглалтын найдвартай ажиллагаа болон өдөр тутмын ажилд аюулгүй байдлыг хангаж хяналт тавьж ажилласан. | |
| 2 | Арга хэмжээ-1.1.2<br>Явган хүний гүүрэн гарцын цахилгаан шатны арчлалт, засварын ажлыг гүйцэтгэнэ. /Их тойруу, 100 айлын уулзварын явган хүний гүүрэн гарцын 2, Их тойруу, Бөмбөгөрийн явган хүний гүүрэн гарцын 2, Чингисийн өргөн чөлөө, 120-ийн явган хүний гүүрэн гарцын 2, Чингисийн өргөн чөлөө, 19 дүгээр хорооллын урд талын явган хүний гүүрэн гарцын 2, нийт 8 цахилгаан шатны арчлалт, засварын ажил/ | 140,500.0<br>ХНАА-н урсгал зардал /УБЗАА/ | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | Тухайн жилийн хэрэгжилтийн хувь, 100 | 100 | Нийслэл хотын хэмжээнд ашиглагдаж байгаа 4 явган хүний гүүрэн гарцын 8 цахилгаан шатуудын засвар, техник үйлчилгээг хариуцан ажиллаж байна. Хан-Уул дүүргийн 1 дүгээр хорооны нутаг дэвсгэрт байрлах 120 мянгатын гүүрэн гарцын цахилгаан шатыг өвлийн улиралд нэмэлт халаагуур суурилуулан хуваарийн дагуу одоог хүртэл ажиллуулж байна. Харин Сүхбаатар дүүргийн 10 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах 100 айлын уулзварын явган хүний гүүрэн гарцын цахилгаан шат, Чингэлтэй дүүргийн 2 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах Бөмбөгөрийн явган хүний гүүрэн гарцын цахилгаан шат, Хан-Уул дүүргийн 3 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах 19 дүгээр хорооллын урд талын явган хүний гүүрэн гарцуудын 6-н ширхэг цахилгаан шатыг ажиллуулах бэлтгэл ажлыг хангаж 2022 оны 4 дүгээр сарын 11, 12-ны өдрүүдэд цэвэрлэгээ үйлчилгээг хийж гүйцэтгэсэн. Гүүрэн байгууламжийн цахилгаан шатуудыг 2022 оны 04 дүгээр сарын 15-ны өдрөөс 2022 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр хүртэл хуваарийн дагуу хэвийн ажиллуулсан. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Нийслэлийн Засаг даргын 2022 оны 10 дугаар сарын 11-ний өдрийн А/1320 дугаар эрх шилжүүлэх тухай захирамж, Улаанбаатар хотын ерөнхий менежерийн 2022 оны 11 дүгээр сарын 09-ний өдрийн Гүүрийн байгууламж, нүхэн гарцын байгууламжийн ашиглалт, үйлчилгээний ажил гүйцэтгүүлэх тухай А/227 дугаар тушаалын хүрээнд Нийслэлийн хэмжээнд ашиглагдаж буй 4 гүүрэн гарцын 8 цахилгаан шатны хонгилд цахилгаан халаагуур суурилуулж, хонгилын дулаалгыг хийж гүйцэтгэн хүйтний улиралд ажиллуулах бэлтгэл ажлыг хангаж, цахилгаан шатны өдөр тутмын хэвийн ажиллагааг хариуцан ажиллаж байна. | |
| 3 | Арга хэмжээ-1.1.3 "UB ENGINEERING" төслийн мэдээллийн сангийн дата бүрдүүлэх, мэдээллийн санг хөгжүүлэх. | - | Улаанбаатар хотын цахилгаан шатны нэгдсэн мэдээллийн санг хөгжүүлэх | - | Улаанбаатар хотын цахилгаан шатны нэгдсэн систем "UB ENGINEERING" системд хөгжүүлэлт хийсэн байна. | "UB ENGINEERING" төслийн мэдээллийн сангийн дата бүрдүүлэх, мэдээллийн сан бүрдүүлэх ажлын хүрээнд манай байгууллагад бүртгэлтэй байгаа 2298 лифтний мэдээллийг оруулсан бөгөөд гэрээгээр хариуцан ажилладаг 163 лифтний мэдээллийг оруулсан. | 100% |
| 4 | Арга хэмжээ-1.1.4 Цахилгаан шатны итгэмжлэгдсэн техникийн хяналтын байгууллага болох. | - | Итгэмжлэгд-сэн техникийн хяналтын байгууллага болох | - | Итгэмжлэгд-сэн техникийн байгууллага | Итгэмжлэгдсэн техникийн хяналтын байгууллага болоход “Зөвлөх үйлчилгээ” үзүүлэх байгууллагын сонгон шалгаруулах тендерийг УБЗАА-аас зарласан боловч төсөвт өртөг хүрэлцэхгүйн улмаас | - |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | болсон байна. | шалгаруулалтад оролцогч ороогүй тул 2022 онд төсөвт өртөгийг нэмж дахин зохион байгуулахаар болсон. Төсөвт өртөг нэмүүлэх хүсэлтийг Улаанбаатар хотын Ерөнхий менежер бөгөөд Захирагчийн Ажлын албаны даргад 2022 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн 17 дугаартай албан бичгээр хүргүүлсэн. Төсөвт өртөг нэмүүлэх асуудлыг шийдвэрлэж өгөөгүйн улмаас тус ажил хэрэгжээгүй байна. | |
| 5 | Арга хэмжээ-1.1.5<br>Гэрээт лифтний тоог нэмэгдүүлнэ. | - | Гэрээ нэмж байгуулсан лифт, тоо | Гэрээ нэмж байгуулсан лифтний тоо, 20 | 20 | Тайлант хугацаанд “Баян төгөл” СӨХ 1 лифт, “Өргөө 144” СӨХ-ны 3 лифт, “Чандмана” СӨХ-ны 3 лифт, “Чинван” СӨХ-ны 1 лифт, “Гандирс” СӨХ-ны 1 лифт, “Оргил-8” СӨХ-ны 7 лифт, “Арт” СӨХ-ны 3 лифт, “G-108” СӨХ-ны 1 лифт, “Улсын хоёрдугаар төв эмнэлэг”-ийн 2 лифт, “Бэрс 2” СӨХ-ны 4 лифт, нийт 26 лифтэнд шинээр засвар, техник үйлчилгээ хийж гүйцэтгэх ажлын гэрээ байгуулсан. Цахилгаан шатны засвар, техник үйлчилгээний ажил гүйцэтгэх гэрээний хугацаа нь дууссан 53 ААНБ, СӨХ-дын 156 лифтний гэрээг сунгаад байна. | 100% |
| 6 | Арга хэмжээ-1.1.6<br>Лифт эзэмшигч, ашиглагч байгууллагуудын удирдлагуудад мэргэжил арга зүйн зөвлөгөөг өгч, шаардлагатай мэдээ, мэдээллээр хангаж ажиллана. | - | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | Тухайн жилийн хэрэгжилтийн хувь, 100 | 100 | Хуваарийн дагуу гэрээт 40 ААНБ, СӨХ-дын лифт эзэмшигч, ашиглагч байгууллагуудын удирдлагуудад мэргэжил арга зүйн зөвлөгөөг ерөнхий инженер М.Энхбат, механик инженер Я.Батбаатар, хяналтын инженер Б.Байгаль нар өгсөн.<br>Мөн цахимаар болон утсаар заавар, зөвлөгөөг өгч, мэдээ, мэдээллээр ханган ажиллаж байна. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 7 | Арга хэмжээ-1.1.7<br>Газрын хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны журмын хэрэгжилтэд хяналт тавих, нийт ажилчдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт жилд 1 удаа хамруулах ажлыг зохион байгуулна. | - | Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан тоо | - | 1 | Газрын хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллаж байна.<br>Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/139 дүгээр тушаал, Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2022 оны 06 дугаар тогтоолын дагуу 2022 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн хүн амыг урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ, оношилгоонд хамруулах үйл ажиллагааг орон даяар хэрэгжүүлж эхлэхтэй холбогдуулан байгууллагын Инженер техникийн хэсгийн албан хаагчдыг энэ үзлэгт хуваарийн дагуу бүрэн хамруулахаар ажиллаж байна. Тайлант хугацаанд 7 ажилтан хуваарийн дагуу хамрагдсан бөгөөд 3 ажилтан дараалла а хүлээж байна. | 90% |
| 8 | Арга хэмжээ-1.1.8<br>Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны давтан болон өдөр тутмын зааварчилгааг тогтмол өгнө. | - | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | Тухайн жилийн хэрэгжилтийн хувь, 100 | 100 | Лифтний механикуудад өдөр тутмын ажлын байран дахь аюулгүй ажиллагааны зааварчилгааг тогтмол, ХАБЭА-н давтан зааварчилгааг улиралд 1 удаа өгч, ХАБЭА-н журмыг мөрдүүлэн аваар осолгүй ажиллаж байна. Инженер техникийн ажилчдад "Улаанбаатар лифт" НӨҮГ-ын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн журмын "Хувийн хамгаалах хэрэгсэл, ажлын хувцас олголт ба ашиглалт" сэдвээр сургалт орж, хамгаалалтын хувцас, багаж хэрэгслээр ханган, хөдөлмөрийн аюулгүй ажиллагааг хангаж ажилласан. | 100% |
| | Арга хэмжээ-1.1.9 | - | Үйл ажиллагааны | Тухайн | 100 | Тайлант хугацаанд инженер техникийн хэсгийн албан хаагчдыг ажлын гутал, бээлий зэрэг шаардлагатай хөдөлмөр хамгааллын | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 9 | Инженер, механикуудын хувцас, багаж хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг хангуулж ажиллана. | | хэрэгжилт, хувь | жилийн хэрэгжилтийн хувь, 100 | | хувцсаар бүрэн хангаж ажилласан. Мөн Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн нөхцөлийг хангахад шаардлагатай нэг удаагийн маск болон анхан шатны тусламжийн хэрэгсэл, өдөр тутмын ажилд шаардлагатай багаж хэрэгслийг шинэчлэн хөдөлмөрийн аюулгүй байдлын нөхцөлийг хангаж ажилласан. | |
| 10 | Арга хэмжээ-1.1.10<br>Ажлын байран дахь аюул ослыг урьдчилан илрүүлэх, түүнийг гэрээт ААНБ, СӨХ-нд мэдэгдэн арилгах ажлыг тогтмол зохион байгуулна. | - | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | Тухайн жилийн хэрэгжилтийн хувь, 100 | 100 | Инженер техникийн хэсгийн албан хаагчдад “Хувийн хамгаалах хэрэгсэл, ажлын хувцас олголт, ба ашиглалт”-ын талаар бататгах сургалт орж, гэрээт ААНБ, СӨХ-дын лифт эзэмшигч нартай уулзалт зохион байгуулж, ажлын байран дахь аюул ослыг урьдчилан илрүүлж, түүнийг гэрээт ААНБ, СӨХ-нд мэдэгдэн арилгах ажлыг тогтмол зохион байгуулан ажилласан. | 100% |
| | | | | | | **Дундаж хувь:** | **98%** |
| **Стратеги төлөвлөгөөний зорилго 2.**<br>Газар нь олгогдсон тусгай зөвшөөрлийн хүрээнд аж ахуй нэгжийн гэрээний үндсэн дээр лифтийн магадлал, туршилтын ажлыг Улаанбаатар хотын нийт лифтэнд хэрэгжүүлнэ. | | | | | | | |
| **Зорилт 2.1**<br>Газар нь олгогдсон тусгай зөвшөөрлийн хүрээнд аж ахуй нэгжийн гэрээний үндсэн дээр лифтийн магадлал, туршилтын ажлыг Улаанбаатар хотын нийт лифтэнд хэрэгжүүлнэ. | | | | | | | |
| 11 | Арга хэмжээ-2.1.1<br>Олгогдсон тусгай зөвшөөрлийн хүрээнд аж ахуйн нэгжийн хүсэлтийн дагуу лифтийн техникийн ээлжит магадлал, туршилтын ажлыг гүйцэтгэх. | - | Магадлал хийх лифт, тоо | Магадлал хийсэн лифтний тоо, 175 | 150 лифтэнд магадлал хийж, 10,500,000 төгрөгийн орлого төвлөрүүлнэ. | Тайлант хугацаанд гэрээгээр хамтран ажилладаг ААНБ, СӨХ-дын хүсэлт болон МХЕГ-тай хамтран ажиллах гэрээний хүрээнд лифт ашиглагч байгууллагын хүсэлтийн дагуу нийт 72 ААНБ, СӨХ-дын 365 лифтэнд техникийн ээлжит магадлалыг хийж гүйцэтгэсэн. Магадлалаар илэрсэн зөрчлийг лифт ашиглагч байгууллага болон засвар, техник үйлчилгээ хариуцагч мэргэжлийн байгууллагад мэдэгдэн арилгуулж, заавар | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | зөвлөгөөг өгч, лифтний хэвийн ажиллагааг хангуулан ажилласан. Мөн лифт ашиглагч болон эзэмшигч байгууллагын хүсэлтийн дагуу 16 ААНБ, СӨХ-ны 22 лифтийг газар дээр нь үзэж шалган гэмтлийг тогтоож, техникийн гэмтлийн акт үйлдэн холбогдох газарт хүргүүлсэн.<br><br>Мөн гэрээний хүрээнд ашиглалтын хугацаа дууссан болон ашиглалтын шаардлага хангахгүй 139 лифтний судалгааг шинэчлэн гаргасан. | |
| 12 | Арга хэмжээ-2.1.2<br>ЛТААД-ийн дагуу лифтний магадлалын актыг үйлдэж, хувийг Мэргэжлийн хяналтын байгууллагад хүргүүлж ажиллана. | - | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | Тухайн жилийн хэрэгжилтийн хувь, 100 | 100 | Техникийн ээлжит магадлал хийж гүйцэтгэсэн 365 лифтийн магадлалын актын хувийг ЛТААД-д заасан хугацаанд НМХГ-т хүргүүлж ажилласан. | 100% |
| 13 | Арга хэмжээ-2.1.3<br>МХЕГ, УБЗАА, “Улаанбаатар лифт” НӨҮГ-ын хамтран ажиллах гэрээний дагуу нийслэлийн хэмжээнд ашиглагдаж байгаа болон ашиглалтын хугацаа дууссан, шинэчлэгдэх шаардлагатай лифтний жагсаалтыг гаргах, бүрэн болон ээлжит магадлалыг цаг алдалгүй хийж, төрийн байгууллагуудын хамтын ажиллагаа, ажлын уялдаа | - | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | Тухайн жилийн хэрэгжилтийн хувь, 100 | 100 | МХЕГ, УБЗАА, “Улаанбаатар лифт” НӨҮГ-ын хамтран ажиллах гэрээний хүрээнд нийт 283 лифтэнд техникийн ээлжит магадлалыг хийж гүйцэтгэсэн.<br>Мөн гэрээний хүрээнд ашиглалтын хугацаа дууссан болон ашиглалтын шаардлага хангахгүй 139 лифтний судалгааг шинэчлэн гаргасан. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | холбоог сайжруулж, хамтран ажиллана. | | | | | | |
| | | | | | | **Дундаж хувь:** | **100%** |
| **Стратеги төлөвлөгөөний зорилго 3.**<br>Улс орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар шинэчлэгдэж буй лифтийн зураг төсөв боловсруулах, захиалагчийн хяналт хийх ажлыг зохион байгуулна. | | | | | | | |
| **НЗДҮАХ-6.1.10**<br>Нийтийн зориулалттай орон сууцны цахилгаан шат, дээвэр, фасад, инженерийн шугам сүлжээг өргөтгөн шинэчилж иргэдийн ая тухтай орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ. | | | | | | | |
| **НХТЖҮЧ-9.8.3**<br>9.8.3. Нийтийн зориулалттай орон сууцны барилгын ашиглалтын шаардлага хангахгүй цахилгаан шатыг шинэчилсэн байна. | | | | | | | |
| **Зорилт 3.1**<br>Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар шинэчлэгдэж буй лифтийн зураг төсөв боловсруулах, захиалагчийн хяналт хийх ажлыг зохион байгуулна. | | | | | | | |
| 14 | Арга хэмжээ-3.1.1<br><br>Нийтийн зориулалттай орон сууцны барилгын ашиглалтын шаардлага хангахгүй цахилгаан шатыг шинэчилсэн байна. | 740,000.0 ОНХСан<br>1,301,000.0 НТ | Ажил гүйцэтгэх гэрээ байгуулснаас хойшхи гүйцэтгэл, тоо | 51 | 43 | - Нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 2021-2022 оны дамжин хэрэгжсэн нийтийн зориулалттай орон сууцны барилгын 8 цахилгаан шатны шинэчлэлийн ажил бүрэн хэрэгжиж дууссан.<br>- Нийслэл, нийслэлийн орон нутгийн сангийн хөрөнгө оруулалтаар 2022 онд хэрэгжиж буй нийтийн зориулалттай орон сууцны барилгын 20 цахилгаан шатны шинэчлэлийн ажил хэрэгжиж байна. Тус 20 цахилгаан шат шинэчлэлийн ажлаас нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж байгаа 10 цахилгаан шатны ажил гүйцэтгэх гэрээ байгуулагдах шатандаа явж байна. Харин нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй 9 цахилгаан шатны шинэчлэлийн ажлын гэрээ байгуулагдсан бөгөөд гэрээний дагуу цахилгаан шатны захиалга хийгдсэн, мөн 1 | 80% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | цахилгаан шатны худалдан авах ажиллагаа зохион байгуулагдаж байна.<br>Монгол Улсын Засгийн Газар, Бүгд Найрамдах Беларусь Улсын Засгийн Газрын хөнгөлөлттэй зээлийн хүрээнд “Улаанбаатар хотын нийтийн зориулалттай орон сууцны 139 цахилгаан шатыг шинэчлэх төсөл”-ийг шинэчлэн боловсруулж, УБЗАА-нд хүргүүлсэн. Төслийн хүрээнд шинэчлэгдэх ашиглалтын хугацаа нь дууссан 139 лифтний хонгилын хэмжилт хийх ажлыг 2022 оны 04 дүгээр сарын 01-13-ны өдрүүдэд Беларусь Улсын “Могилевлифтмаш” ХК-ийн инженер техникийн ажилчид болон “Улаанбаатар лифт” НӨҮГ-ын инженер техникийн ажилчид хамтран гүйцэтгэсэн. Дээрх төслийн зээлийн эргэн төлөлт нь тодорхойгүй, цаг үеийн нөхцөл байдал (дайны нөхцөл)-аас шалтгаалан хэрэгжих нь тодорхойгүй болсон тул нийслэлийн 2022 оны төсвийн “Нийслэлийн хөрөнгө оруулалтаар 2022 оны төсвийн жилд хэрэгжүүлэх их засварын төсөл, арга хэмжээний жагсаалт”-ын 24.1.10-т батлагдсан “Нийтийн зориулалттай орон сууцны цахилгаан шат шинэчлэлт” төсөл, арга хэмжээний 1,301.0 (нэг тэрбум гурван зуун нэг сая) төгрөгөөр ашиглалтын хугацаа дууссан нэн түрүүнд яаралтай шинэчлэх шаардлагатай 10 цахилгаан шатыг шинэчлэн солих саналыг 2022 оны 09 дүгээр сарын 21-ны өдрийн 216 дугаартай албан бичгээр НЗДТГ-т хүргүүлж, тус саналын дагуу 10 цахилгаан шинэчлэгдэж байна. (2022 онд хэрэгжиж буй хөрөнгө оруулалтын ажлуудын хувьд Нийслэлийн худалдан авах ажиллагааны газраас гүйцэтгэгч сонгон шалгаруулах тендерийг зохион байгуулан | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ажилласан бөгөөд гүйцэтгэгч сонгон шалгаруулах явц удаашралтай явагдсан учраас тус ажлууд хугацаа хоцорч хэрэгжиж байна.) | |
| 15 | Арга хэмжээ-3.1.2<br><br>Нийтийн зориулалттай орон сууцны ашиглалтын шаардлага хангахгүй байгаа лифтнүүдийн судалгааг гаргаж НЗДТГ, УБЗАА-нд хүргүүлнэ. | - | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | Тухайн жилийн хэрэгжилтийн хувь, 100 | 100 | Нийтийн зориулалттай орон сууцны ашиглалтын хугацаа дууссан болон ашиглалтын шаардлага хангахгүй 139 лифтнүүдийн судалгааг гаргаж УБЗАА-нд хүргүүлсэн. | 100% |
| | | | | | | **Дундаж хувь:** | **90%** |
| **Стратеги төлөвлөгөөний зорилго 4.**<br>Лифтийн ашиглалт үйлчилгээний салбарыг мэргэжилтэй боловсон хүчнээр бэхжүүлэх, тэдний мэдлэг мэргэжлийг дээшлүүлэх, гадаад дотоодын сургалтад хамруулах, ажилтнуудыг байнгын курсээр бэлтгэх, давтан сургах | | | | | | | |
| **Зорилт 4.1**<br>Лифтчин бэлтгэх сургалтад иргэдийг бүртгэж, сургалтыг зохион байгуулна. | | | | | | | |
| 16 | Арга хэмжээ-4.1.1<br>Хамтран ажиллах гэрээний дагуу шинээр лифтчин бэлтгэх сургалтад иргэдийг бүртгэж, сургалтыг зохион байгуулна. | - | Мэргэжилтэй лифтчин бэлтгэх, тоо | Мэргэжилтэй лифтчин бэлтгэсэн тоо, 42 | 30 | “Монкран консалтинг” ХХК-тай хамтран 01 дүгээр сарын 10-14, 04 дүгээр сарын 04-08-ны өдрүүдэд лифтчин бэлтгэх сургалтыг зохион байгуулж, өөрийн гэрээт СӨХ-дын лифтэнд дадлага хийлгэж, нийт 15 хүн сургаж, мэргэжлийн үнэмлэхээр хангаж мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэж ажилласан. Мөн 03 дугаар сарын 01, 04 дүгээр сарын 14-ний өдрүүдэд лифтчин бэлтгэх давтан сургалт зохион байгуулж 33 лифтчинг хамруулж, мэргэжлийн үнэмлэхийн сунгалтыг хийсэн. | 100% |
| | Арга хэмжээ-4.1.2 | - | Сургалтад хамрагдсан | Сургалтад хамрагдсан | | “Монкран консалтинг” ХХК-тай хамтран ажиллах гэрээний хүрээнд манай | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 17 | Мэргэжлийн сургалтын төвд механикуудыг сургалтад хамрагдах ажлыг зохион байгуулах. | | механикуудын тоо | механикуудын тоо, 5 | 5 | байгууллагын 5 механик мэргэжлийн үнэмлэх сунгах шалгалтад хамруулж, мэргэжлийн үнэмлэхийг 6 дугаар сард хуваарийн дагуу сунгуулсан. | |
| 18 | Арга хэмжээ-4.1.3<br>Лифтийн ашиглалт хариуцагч нарын сургалт, мэргэжил дээшлүүлэх зохион байгуулах. | - | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | Тухайн жилийн хэрэгжилтийн хувь, 100 | 100 | Гэрээт ААНБ, СӨХ-ны удирдлагуудтай уулзах, хяналт шалгалт хийх, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх хуваарь гаргаж, хуваарийн дагуу 3, 4 дүгээр сард “Өргөө 14” СӨХ, “Бэгдү хотхон” СӨХ, “Оргил 8” СӨХ зэрэг 28 СӨХ-дын гүйцэтгэх захиралуудтай биечлэн уулзаж ЛТААД-ийг таниулах ажлыг зохион байгуулж мөн лифтний аюулгүй ажиллагааг хангаж ажиллах талаар харилцан санал солилцсон. | 100% |
| | | | | | | **Дундаж хувь:** | **100%** |

**Стратеги төлөвлөгөөний зорилго 5.**

**Төрийн захиргаа, хүний нөөцийн удирдлагын манлайллыг хангаж, албан хаагчдын мэдлэг чадварыг дээшлүүлж, байгууллагын соёл, ёс зүй, сахилга хариуцлагыг өндөржүүлэн, газрын өмнө тавигдсан зорилго, зорилтуудыг хэрэгжүүлэх мэргэшсэн, чадварлаг аппарат бүрдүүлж, газрын үйл ажиллагааг нээлттэй, ил тод, төрийн үйлчилгээг чирэгдэлгүй, хариуцлагатай болгох, иргэд аж ахуйн нэгж байгууллагын хүсэлт, албан бичиг, өргөдөл гомдлыг хүлээн авч хуулийн хугацаанд нийслэлээс дэвшүүлсэн зорилтот түвшинд шийдвэрлэнэ.**

**НЗДҮАХ-4.1.4**

Төрийн байгууллагын үйл ажиллагааны мэдээллийн ил тод байдлыг нэмэгдүүлж, иргэд, олон нийтийн оролцоог хангана.

**Зорилт 5.1**

Газрын үйл ажиллагааг нээлттэй, ил тод байдлын талаар

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 19 | Арга хэмжээ-5.1.1<br><br>Байгууллагын зорилго, үйл ажиллагааны үндсэн чиглэл, бүтэц, зохион байгуулалт, харилцах утас зэрэг мэдээллийг | - | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь, 100 | 100 | 2022 оны 01 дүгээр сард байгууллагын www.ublift.ub.gov.mn цахим хуудсанд байрлах танилцуулга, зорилго, зорилт, ажилтнуудын и-мэйл хаяг, харилцах утасны жагсаалт зэрэг мэдээллийг шинэчлэн байршуулсан. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | байгууллагын цахим хуудсанд өөрчлөгдсөн тухай бүр шинэчлэн байршуулж баяжуулна. | | | | | Цаг үеийн болон бусад 60 мэдээ, мэдээллийг тухай бүр байршуулан ажиллаж байна. | |
| 20 | Арга хэмжээ-5.1.2<br><br>Үйлчилгээ авахад шаардагдах бичиг баримтын жагсаалтыг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчилнэ. | - | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь, 100 | 100 | Байгууллагаас үзүүлж буй ажил, үйлчилгээ авахад шаардагдах бичиг баримтын жагсаалтыг ublift.ub.gov.mn цахим хуудаснаа байршуулан тухай бүрт шинэчилж байна. | 100% |
| 21 | Арга хэмжээ-5.1.3<br><br>Үзүүлж байгаа ажил үйлчилгээний талаарх мэдээ, мэдээллийг тухай бүр цахим хуудас болон мэдээллийн самбартаа байршуулна. | - | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь, 100 | 100 | Жилийн эцсийн байдлаар байгууллагын www.ublift.ub.gov.mn цахим хуудсанд үйл ажиллагаа, төсөв санхүү, хүний нөөцийн ил тод байдалтай холбоотой нийт 25 мэдээлэл, мэдээллийн самбарт дээд байгууллагаас ирүүлсэн тогтоол, захирамж, төсөв санхүү, хүний нөөцийн ил тод байдал, сахилга хариуцлага, ёс зүйтэй холбоотой 35 мэдээллийг тус тус байршуулсан. | 100% |
| 22 | Арга хэмжээ-5.1.4<br><br>Сул орон тооны зарыг байгууллагын цахим хуудас болон мэдээллийн самбартаа байршуулж ажиллана. | - | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь, 100 | 100 | Ажлын сул орон тоог байгууллагын www.ublift.ub.gov.mn цахим хуудсанд байршуулж ил тод зарлан, сонгон шалгаруулж ажилд авч байна. 2022 оны байдлаар зарын дагуу иргэдээс анкет болон ажилд орох хүсэлтээ ирүүлснээс Ахлах нягтлан бодогч-1, Жолооч-1, Хяналтын инженер-2 буюу нийт 4 ажилтныг тус тус сонгон шалгаруулж ажилд авсан. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 23 | Арга хэмжээ-5.1.5<br><br>Хүний нөөцийн удирдлагын ил тод байдлыг хангах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар мэдээллийн самбартаа байршуулна. | - | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь, 100 | 100 | “Хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан баталж, хэрэгжилтийг 98 хувийн гүйцэтгэлтэй хангаж ажиллаж байна. Энэ талаар авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээг мэдээллийн самбартаа тухай бүр байршуулдаг ба ажилчдын шуурхай зөвлөгөөн дээр танилцуулан ажиллаж байна. Хэрэгжилтийн мэдээ тайланг 2022 оны 06 дугаар сарын 30-ны өдөр НЗДТГ-т хүргүүлсэн. | 98% |
| 24 | Арга хэмжээ-5.1.6<br><br>Ажилчдын ажлын гүйцэтгэлийг үнэлэх үйл ажиллагааг үнэн зөв, шударга болгох чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар ажилчдын шуурхай зөвлөгөөнөөр мэдээлж ажиллана. | - | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь, 100 | 100 | Албан хаагчид хийж хэрэгжүүлэх үйл ажиллагаагаа сар, улирал жилийн хугацаатайгаар төлөвлөдөг ба гүйцэтгэл, үр дүнг ажилчдын шуурхай зөвлөгөөнөөр хэлэлцэн, дүгнэж ажилласан.<br><br>Ажилтнуудын ажлын гүйцэтгэлийг 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө, ажлын байрны тодорхойлолт болон хөдөлмөрийн гэрээтэй уялдуулан дүгнэсэн. | 100% |
| **НЗДҮАХ-4.1.4.1**<br>Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын “Шилэн дансны тухай хууль”-ийн хэрэгжилтэд хяналт тавьж төсөв, санхүүгийн ил тод байдлыг хангуулна. | | | | | | | |
| 25 | Арга хэмжээ-5.1.7<br><br>Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэн мөрдөж, санхүүгийн мэдээ мэдээллийг хуулийн | - | Сар бүр мэдээллийг хуулийн дагуу ил тод | 12 удаа мэдээллийг хуулийн дагуу ил тод мэдээлсэн. | 12 | Төсвийн хөрөнгийн зарцуулалтын дүн мэдээг сар бүр 24 удаа шилэн дансны http://www.shilendans.ub.gov.mn/home цахим хуудсанд бүртгэж үйл ажиллагаандаа шилэн | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хугацаанд нь оруулж ажиллана. | | мэдээлсэн байдал, тоо | | | дансны тухай хуулийг мөрдөн хэрэгжүүлж ажилласан. | |
| **НЗДҮАХ-3.1.4**<br>Төрийн худалдан авах ажиллагаагаар дамжуулан дотоодод үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний худалдан авалтыг дэмжинэ. | | | | | | | |
| **НХТЖҮЧ-4.1.5**<br>Төрийн худалдан авах ажиллагаагаар дамжуулан дотоодод үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний худалдан авалтыг дэмжсэн байна. | | | | | | | |
| 26 | Арга хэмжээ-5.1.8<br>Дотоодын үйлдвэрлэгчдээс нийлүүлэх боломжтой барааг "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль"-ийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх заалтыг баримтлан худалдан авах ажиллагааг зохион байгуулна. | - | Хуулийн дагуу худалдан авах ажиллагааг зохион байгуулсан байх, хувь | Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь, 100 | 100 | Дотоодод үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний худалдан авалтыг дэмжиж "Элит хангамж" ХХК-аас 78,000.0 төгрөгийн принтерийн хор, "Бат сежү" ХХК-аас 850,000.0 төгрөгийн ажлын бээлий худалдан авсан. | 100% |
| 27 | Арга хэмжээ-5.1.9<br>http://city.audit.mn цахим хуудсанд санхүүгийн тайланг шивж оруулна. | - | Цахим хуудсанд санхүүгийн тайланг оруулсан тоо | Цахим хуудсанд санхүүгийн тайланг оруулсан тоо, 1 | 1 | 2022 оны 02 дугаар сарын 10-ны өдөр http://city.audit.mn цахим хуудсанд 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг шивж оруулсан. | 100% |
| 28 | Арга хэмжээ-5.1.10<br>Салбарын хэмжээнд улсын төсвийн хөрөнгөөр болон гадаадын зээл, | - | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь, 100 | 100 | Тайлант хугацаанд улсын төсвийн хөрөнгөөр болон гадаадын зээл тусламжаар хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөр байхгүй болно. | - |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | тусламжаар хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт, явц байдлын талаарх мэдээллийг цахим хуудсандаа байрлуулан тухай бүр шинэчилнэ. | | | | | | |
| 29 | Арга хэмжээ-5.1.11<br>Иргэд аж ахуйн нэгж байгууллагын хүсэлт, албан бичиг, өргөдөл гомдлыг хүлээн авах эх үүсвэрийг нэмэгдүүлж, шийдвэрлэлтийн чанар, үр дүнг сайжруулж хуулийн хугацаанд нийслэлээс дэвшүүлсэн зорилтот түвшинд шийдвэрлэнэ. | - | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь, 100 | 100 | Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын нэгдсэн систем erp.ulaanbaatar.mn нэгдсэн сайтаар 2022 оны жилийн эцсийн байдлаар нийт 18 өргөдөл гомдол, хүсэлт ирсэн бөгөөд тухай бүр шуурхай шийдвэрлэн ажилласан байна.<br>Иргэд аж ахуйн нэгж байгууллагын хүсэлт, албан бичиг, өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн чанар, үр дүнг сайжруулж хуулийн хугацаанд нийслэлээс дэвшүүлсэн зорилтот түвшинд шийдвэрлэсэн.<br>Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн мэдээг 2022 оны 12 дугаар сарын 10-ны өдрөөс 25-ны өдрийг хүртэлх хугацаанд өдөр бүр батлагдсан маягтын дагуу Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлэн ажилласан. | 100% |
| 30 | Арга хэмжээ-5.1.12<br>Байгууллагын удирдах албан тушаалтнуудын иргэдтэй хийх уулзалтыг хуваарийн дагуу тогтмолжуулж, шийдвэрлэлтийн үр дүнг тооцон, иргэдээс тусгасан | - | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь, 100 | 100 | Байгууллагын удирдах албан тушаалтнуудын иргэдтэй хийх уулзалтыг хуваарийн дагуу тогтмолжуулж, шийдвэрлэлтийн үр дүнг тооцон, иргэдээс ирүүлсэн санал, хүсэлтийг үйл ажиллагаандаа тусган ажиллаж байна. Иргэдээс ирүүлсэн (цахимаар, утсаар, албан бичгээр) санал хүсэлтийг хуулийн хугацаанд | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | санал, хүсэлтийг үйл ажиллагаандаа тусган ажиллана. | | | | | шуурхай шийдвэрлэн үйл ажиллагаандаа тусган ажиллаж байна. | |
| **НЗДҮАХ-4.1.1.3**<br>Тоон гарын үсгийг нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын хэрэглээнд бүрэн нэвтрүүлж, албан бичгийн харилцааг бүрэн цахимжуулна. | | | | | | | |
| **Зорилт 5.2**<br>Төрийн үйлчилгээг чирэгдэлгүй, хариуцлагатай болгох, иргэд аж ахуйн нэгж байгууллагын хүсэлт, албан бичиг, өргөдөл гомдлыг хүлээн авч хуулийн хугацаанд нийслэлээс дэвшүүлсэн зорилтот түвшинд шийдвэрлэнэ. | | | | | | | |
| 31 | Арга хэмжээ-5.2.1<br>Тоон гарын үсгийг хэрэглээнд нэвтрүүлж, албан бичгийн харилцааг цахимжуулна. | - | Тоон гарын үсгийг хэрэглээнд нэвтрүүлэх, хувь | Тоон гарын үсгийг хэрэглээнд нэвтрүүлэх, 60 | 100 | Тоон гарын үсгийг 9 ажилтан хэрэглээнд нэвтрүүлж, албан бичгийн харилцааг цахимжуулсан. | 100% |
| 32 | Арга хэмжээ-5.2.2<br>Иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудаас ирсэн албан бичгийн шийдвэрлэлт болон нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын дотоод удирдлагын систем www.erp.ulaanbaatar.mn цахим хуудсыг хөтлөнө. | - | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | Тухайн жилийн хэрэгжилтийн хувь, 100 | 100 | Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын дотоод удирдлагын нэгдсэн www.erp.ulaanbaatar.mn системийн edoc программд байгууллагад ирсэн албан бичгийг хүлээн авч байгууллагын "Албан хэрэг хөтлөлтийн журам"-ын дагуу ангилан бүртгэж, холбогдох ажилтанд шилжүүлэн ажиллаж байна. 2022 оны жилийн эцсийн байдлаар нийт 365 албан бичиг бүртгэгдсэнээс 83 хариутай албан бичиг хүлээн авсан ба тухай бүр хугацаанд нь хариу өгч шийдвэрлэж ажилласан.<br>Нийт явуулсан албан бичиг 295 байна.<br>Албан бичгийн шийдвэрлэлтийн байдалд болон хариутай албан бичгийг хугацаанд нь шийдвэрлэж байгаа эсэхэд тогтмол хяналт тавин зөрчилгүй ажилласан байна. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
